



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02

Сангийндалай

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, 32.1.3 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2024 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийт нутгаар цас орж, өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч болзошгүй байгаатай холбогдуулан сумын хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан гамшгаас хамгаалах тухай хууль, улс, аймгийн онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Сумын шуурхай штаб, байгууллагын дарга удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (О.Базаррагчаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЛХАГВАМАНДАЛ

482402003